



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 842

Улаанбаатар хот

**Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний
тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн Барилга, хот байгуулалтын яамны 2022 оны төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалтын үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 185,973,800,000 (нэг зуун наян таван тэрбум есөн зуун далан гурван сая найман зуун мянган) төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.Барилга, хот байгуулалтын яамны төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалтын үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал түүнийг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбатад төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт болон дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай.

2.1.Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган, зөрчлийг давтан гаргахгүй байх;

2.2.Барилга, хот байгуулалтын яамны нэр дээрх 233058 м.кв талбай бүхий 24 ширхэг газар эзэмших эрхийн ашиглалтыг тогтоож, Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоол, холбогдох журмыг үндэслэн үнэлж бүртгэх, гадаадын зээл, тусламж, төслийн хүрээнд бий болсон, улсын комисс хүлээн авч шилжүүлсэн хөрөнгөд хамаарах газар эзэмших эрхийг ашиглагч байгууллагад шилжүүлж данс бүртгэлд тусгуулах;

2.3.Барилга, хот байгуулалтын яамны нэгдсэн санхүүгийн тайлангийн бусад эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, гадаадын зээл, тусламж, төсөл хөтөлбөр болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг байнгын ашиглалтад хүлээн авсан дүгнэлт, тоног төхөөрөмж хүлээн авсан акт, зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэлийг захиалагч хүлээн авсан хөрөнгийг холбогдох хууль, дүрэм журамд нийцүүлэн төрийн болон орон нутгийн өмчид бүртгүүлэх арга хэмжээ авах;

2.4.Гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл арга хэмжээний маргаантай байгаа 12,585,172,757 (арван хоёр тэрбум таван зуун наян таван сая нэг зуун далан хоёр мянга долоон зуун тавин долоон) төгрөгийн хөрөнгийн бүртгэлийн асуудлыг шийдвэрлэж, ашиглагч байгууллагын данс бүртгэлд тусгуулах;

123007419
37-r huraldaan.docx

2.5.Төрийн болон орон нутгийн өмчийн 2022 оны улсын үзлэг, тооллогын баримтыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтыг газарт хүргүүлэх;

2.6.Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийг актлах, цаашид ашиглах боломжтой хөрөнгийн ашиглалтын жил, өртгийг шинэчлэн тогтоож бүртгэх;

2.7.Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед хөрөнгө, өр төлбөрийн тооллогын заавал хийж, байгууллагын дотоод журмын дагуу ажил хүлээлцэж байх;

2.8.Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан Дотоод аудитын дүрмийн 5.1.2 дахь заалтыг мөрдөж, төрийн өмчийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалтын байдалд хяналт тавих ажлыг дотоод хяналтын хорооны тухайн жилийн ажлын төлөвлөгөөнд тусгах;

2.9.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдлөг болгон ажиллах;

2.10.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн
84/2 дугаар тогтоолын хавсралт



Барилга, хот байгуулалтын яаманд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил,
дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын утга	Үнийн дүн /сая төгрөг/	Зөрчигдсөн эрхзүйн акт	Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон, бусад эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийг ашиглагч байгууллагын хөрөнгөд бүртгүүлээгүй	185,900	Төсвийн тухай хууль, Нягтлах бодох бүртгэлийн тухай хууль,	Яамны нэгдсэн санхүүгийн тайлангийн бусад эргэлтийн хөрөнгийн данс дахь хөрөнгийг ашиглагч байгууллагын хөрөнгөд бүртгэж байх
2	Барилга, хот байгуулалтын яамны нэр дээрх 233058 м.кв талбай бүхий 24 ширхэг газар эзэмших эрхийн ашиглалтыг тогтоож, үнэлж, бүртгүүлээгүй	-	Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоол, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоол	Газар эзэмших эрхийн ашиглалтыг тогтоож, төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгөд хамаарах газар эзэмших эрхийг ашиглагч байгууллагад шилжүүлж бүртгүүлж байх
3	Тээврийн хэрэгсэл шилжүүлэх тогтоолоос зөрүүтэй дүнгээр үндсэн хөрөнгийг данснаас хассан	73.8	ТӨБЗГ-ын 2022 оны 326, 360 дугаар тогтоол	Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг үнэн зөв хэрэгжүүлэх
НИЙТ ДҮН:		185,973,800,000 (нэг зуун наян таван тэрбум есөн зуун далан гурван сая найман зуун мянган)		